

**ИОННамын Төлөөлөгчдийн Танхимын
2023 оны Тавдугаар хурлын
ТОГТООЛ**

2023 оны 4 дүгээр сарын 11

Дугаар 01

Улаанбаатар хот

Хурлын нарийн бичгийн дарга сонгох тухай

Иргэдийн Оролцооны Нэгдэл намын Төлөөлөгчдийн Танхимын хурлаас ТОГТООХ
нь:

Нэг. Төлөөлөгчдийн Танхимын хурлын нарийн бичгийн даргаар төлөөлөгч
Р.Отгончимэгийг сонгосугай.

ДАРГА _____

**Иргэдийн Оролцооны Нэгдэл Намын Төлөөлөгчдийн Танхимын
2023 оны Тавдугаар хурлын тогтоол**

2023 оны 4 дүгээр сарын 11

Дугаар 02

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Иргэдийн Оролцооны Нэгдэл намын дүрмийн 17.3, 9.6.9 дахь заалтыг тус тус үндэслэн Төлөөлөгчдийн Танхимын хурлаас ТОГТООХ нь:

1. Иргэдийн Оролцооны Нэгдэл Намаас төрийн сонгуульд нэр дэвшүүлэх, боловсон хүчнийг шилж сонгох үйл ажиллагааг зохицуулах журам-ыг хавсралтаар баталсугай.

Дарга:

Нарийн бичгийн дарга:

_____.

ИРГЭДИЙН ОРОЛЦООНЫ НЭГДЭЛ НАМААС ТӨРИЙН СОНГУУЛЬД НЭР ДЭВШҮҮЛЭХ, БОЛОВСОН ХҮЧНИЙГ ШИЛЖ СОНГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Төрийн сонгуульд ИОНН-ыг төлөөлж нэр дэвшүүлэх байгууллага

- 1.1 Намын дараах байгууллага ИОНН-ыг төлөөлж дараах сонгууль, албан тушаалд нэр дэвшүүлэх байгууллага байх бөгөөд нам улс төрийн сонгуульд оролцох тухай төрийн байгууллагад илэрхийлнэ. Үүнд:
 - 1.1.1. УИХ, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуульд намаас нэр дэвшүүлэх байгууллага нь ИОНН-ын Төлөөлөгчдийн Танхим байна.
 - 1.1.2. Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшүүлэх байгууллага нь нийслэлийн Танхим байна. Нийслэлийн танхим байгуулагдаагүй байгаа үед уг сонгууль болбол нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд нэр дэвшүүлэх байгууллага нь салбар байгуулагдсан нэг дүүргийн танхим, эсвэл намын салбар бүхий дүүргүүдийн танхимын хамтарсан хурал байна.
 - 1.1.3. Аймаг, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуульд нэр дэвшүүлэх байгууллага нь тухайн аймаг дүүргийн танхим байна. Хэрэв аймаг, дүүрэгт салбар байгуулагдаагүй бол тухайн аймаг, дүүрэг дэх салбар байгуулагдсан нэг сум, хорооны танхим, эсвэл намын салбар бүхий сум, хороодын танхимын хамтарсан хурал байна.
 - 1.1.4. Сумын иргэдийн төлөөлөгчдийн хурал, баг, хорооны иргэдийн нийтийн хурлын тэргүүлэгчдийн сонгуульд ИОНН-аас нэр дэвшүүлэх байгууллага нь тухайн сум, хорооны танхим байна.
- 1.2. Төрийн сонгуульд байгууллагад ИОНН олонхи болсон, эсвэл өөр нам, эвсэлтэй хамтран олонхийг бүрдүүлэх тохиолдолд дараах түвшний албан тушаалтныг намын дараах байгууллагаас санал болгож уламжилна. Үүнд:
 - 1.2.1. Монгол улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайдын албан тушаалд нэр дэвшигчийг Төлөөлөгчдийн танхим санал болгож УИХ дахь намын бүлэгт уламжилна.
 - 1.2.2. Нийслэлийн ИТХ-ын дарга, нийслэлийн засаг даргад нэр дэвшигчийг Нийслэлийн танхим, нийслэлийн танхим байгуулагдаагүй бол салбартай дүүргүүдийн танхим хамтарсан хурлаар тус тус санал болгож Нийслэлийн ИТХ дахь намын бүлэгт уламжилна.
 - 1.2.3. Аймаг, дүүргийн ИТХ-ын дарга, аймаг, дүүргийн засаг даргад нэр дэвшигчийг тухайн аймаг, дүүргийн танхим, уг танхим байгуулагдаагүй бол салбартай сумдын танхим хамтарсан хурлаар тус тус санал болгож аймаг, дүүргийн ИТХ дахь намын бүлэгт уламжилна.
 - 1.2.4. Сумын ИТХ-ын дарга, сумын засаг дарга, Хорооны засаг дарга, Хорооны ИНХ-ын тэргүүлэгчид нэр дэвшигчийг тухайн сум, хорооны танхим санал болгож сумын ИТХ дахь намын бүлэгт болон хорооны ИНХуралд тус тус уламжилна.

Хоёр. Намын гишүүн өөрийгөө илэрхийлэх

2.1. Энэ журмаар зохицуулагдаж буй аливаа нэр дэвшилтийг зөвхөн өөрийгөө илэрхийлсэн намын гишүүдийн хүрээнд авч хэлэлцэнэ.

2.2. Намын гишүүн Намын дүрмийн 17.2-т заасны дагуу дараах хугацаанд, дараах хэлбэрээр өөрийгөө илэрхийлсэн байна.

2.2.1. Улс төрийн хуримтлал үүсгэгч гишүүний болзлыг ээлжит сонгуулийн жил сонгууль болохоос 3 сарын өмнө, ээлжит бус болон нөхөн сонгуулийн үед намын Дотоод сонгууль зохион байгуулах төв ажлын хэсгээс зарласан хугацаанд багтан хангаж Бүртгэгчид бүртгүүлэх;

2.2.2. Төрийн ээлжит сонгуулийн хооронд хамгийн багадаа нэг удаа хандивлагч гишүүнээр бүртгэгдсэн байх. Ээлжит бус, нөхөн сонгуулийн үед намын Дотоод сонгууль зохион байгуулах төв ажлын хэсгээс зарласан хугацаанд багтан хандивлагч гишүүний болзлыг хангаж Бүртгэгчид бүртгүүлэх;

2.2.3. Намын мөрийн хөтөлбөрт нийцсэн идэвхтэй үйл ажиллагааг зохион байгуулах, манлайлах, нийгэмд танигдах;

2.2.4. Намын үйл ажиллагаанд оролцсон оролцоогоор оноо цуглуулах. Байнгын онооны систем хөгжүүлэлт хийгдээгүй үед сонгууль тохиовол өөрийн оролцооны жагсаалтыг нэр дэвшүүлэх байгууллагад Дотоод сонгууль зохион байгуулах төв ажлын хэсгээс зарласан хугацаанд гаргаж өгөх.

2.2.5. Нэр дэвших шат шатныхаа хүрээнд намын мөрийн хөтөлбөр боловсруулахад идэвхитэй оролцох, эсвэл мөрийн хөтөлбөрт оруулах санал, хуулийн төсөл, бодлогын баримт бичгийг санаачилж тухайн шатны намын байгууллагын хурал, эсвэл ИОНН-ын гишүүдийн нээлттэй сургалтанд танилцуулсан, эсхүл хэлэлцүүлсэн байх.

2.2.6. Энэ журмын 2.2.1 ба 2.2.2-т заасны дагуу намын бүртгэгчид бүртгүүлсний дараа Намын дотоод сонгууль зохион байгуулах төв ажлын хэсэгт өөрийн өрсөлдөхийг хүсч буй албан тушаал, сонгуульд өрсөлдөх орон тоо, тойргийн гурав хүртэлх сонголтыг бичиж илгээнэ.

Гурав. Тандалт, үнэлгээ

3.1. Улс төрийн сонгуульд намаас нэр дэвшигчийн тандалт үнэлгээг Намын даргын тушаалаар байгуулагдах Тандалт үнэлгээний ажлын хэсэг зохион байгуулна.

3.2. Тандалт үнэлгээний ажлын хэсэг нь энэ журмын 3.1-д дурдсан тушаалд заасан хугацаанд багтаан, дараахь үйл ажиллагааг зөвхөн Дотоод сонгуулийн төв ажлын хэсгээс ирүүлсэн нэрсийн жагсаалтад үндэслэн зохион байгуулна.

3.2.1. Намын дотоод цахим сүлжээ ашиглан гишүүд, хандивлагч гишүүдийн дунд санал асуулга явуулах.

3.2.2. Нийгмийн сүлжээн дэх танигдалтыг судлах

3.2.3. Нэр дэвшихийг хүсч буй тойрог, сонгогчдын дунд түүвэр судалгаа явуулах

3.3. Энэхүү тандалт, үнэлгээг үнэн зөв зохион байгуулахад шаардлагатай төсвийг Тандалт үнэлгээний ажлын хэсгээс төлөвлөж намын Ерөнхий менежерт хүргүүлнэ.

3.4. Нэг орон тоонд нэгээс олон нэр дэвшигч өөрийгөө илэрхийлсэн бол тандалт, үнэлгээнээс гарсан дүнг хамгийн өндөрөөс бага руу нь дараалуулан эрэмбэлнэ.

3.5. Энэ журамд заасны дагуу 3 хүртэлх сонголттойгоор тойрог, орон тооны жагсаалт ирүүлсэн гишүүнийг мөн тооны судалгаа, тандалтанд хамруулна.

3.6. Тандалт, үнэлгээний ажлын хэсэг нь гаргасан дүгнэлтээ төрийн сонгуульд ИОНН-ыг төлөөлж нэр дэвшүүлэх байгууллагад хаяглан илгээх ба хувийг судалгаанд нэр нь хамрагдсан гишүүнд явуулна.

3.7. Тандалт, үнэлгээний дүгнэлт нь тухайн гишүүний тойргийн сонголт, сонгуулийн сурталчилгааны тактик, сонгуулийн төсвийн төлөвлөлт боловсруулахад баримтлах үндэслэл болно.

Дөрөв. Намын байгууллага шийдвэр гаргах

4.1. Төрийн сонгуульд ИОНН-ыг төлөөлж нэр дэвшүүлэх байгууллага нь аливаа нэр дэвшигчийн асуудлыг хурлаар хэлэлцэхийн өмнө Дотоод сонгууль зохион байгуулах төв ажлын хэсгээс гаргасан нэр дэвшигчдийн жагсаалтыг хүлээн авна.

4.2. Хэрэв нэг орон тоонд нэгээс олон хүн нэр дэвшиж байвал саналын хуудсыг дотоод сонгуулийн төв ажлын хэсэгт бүртгүүлсэн дарааллын дагуу бэлтгэнэ.

4.3. Дотоод сонгуулийн төв ажлын хэсэгт бүртгэгдээгүй сул орон тоонд нэр дэвшүүлэлтийг намын эрх бүхий байгууллагын хурал дээр зохион байгуулж болно.

4.4. Төрийн сонгуульд ИОНН-ыг төлөөлж нэр дэвшүүлэх хурлаар нэр дэвшигч нэр бүрийн онооны дүн, онооны дүн тооцох боломжгүй нөхцөлд өөрийн оролцооны жагсаалт, тандалт үнэлгээний ажлын хэсгийн дүгнэлтийг тус тус сонссоны дараа нэр дэвшихээр бүртгэгдсэн гишүүн бүрт өөрийгөө болон мөрийн хөтөлбөрөө танилцуулах ижил тэнцүү цаг олгоно.

4.5. Энэ журмын 4.4 дэх заалтын дагуу хэлэлцсэний дараа нэр дэвшигчдээс асуух асуултуудыг бүртгэж авч танилцуулна.

4.6. Энэ журмын 4.5-д заасны дагуу бүх асуултыг нэгмөсөн сонссоны дараа нэр дэвшигч бүр хурал даргалагчийн зарласан ижил хугацаанд багтаан өөрт хамааралтай, эсвэл өөрийн сонгосон асуултад хариулна.

4.7. Энэ журмын 4.4- 4.6 дахь ажиллагаа явагдаж дууссаны дараа санал хураалтыг зохион байгуулж, эрх бүхий байгууллагын хуралд оролцогсдоос хамгийн олон хүний санал авсан нэр дэвшигчийг намын нэр дэвшигчээр батална.

Тав. Хүйсийн тэгш байдал, жагсаалт эрэмбэлэх

5.1. Энэ журмын дагуу гарсан шийдвэр нь Монгол улсын хуулийн дагуу шаардсан хүйсийн тэгш байдлыг хангасан байна. Үүний тулд зохих тооны орон тоонд шийдвэр гаргахдаа хүйсийн квотоор нэр дэвшилт явуулж болно.

5.2. Хувь тэнцүүлсэн болон холимог системээр сонгууль явагдах тохиолдолд намын нэр дэвшигчдийн жагсаалтын төслийг Төлөөлөгчдийн танхимын хуралд намын дарга, салбарын танхимын хуралд тухайн салбарын дарга санал оруулж хэлэлцүүлнэ.

5.3. Намын жагсаалтын төслийг боловсруулахдаа Намын дарга, салбарын дарга нар дараах үзүүлэлтийн нийлбэрийг харгалзан үзсэн байна. Үүнд:

5.3.1. Өөрийгөө илэрхийлсэн эсэх

5.3.2. Намын үйл ажиллагаанд оролцсон оноо ба жасгаалт

5.3.3. Тандалт, үнэлгээний дүгнэлт

5.3.4. Хуулиар заасан жендерийн харьцаа

Зургаа. Журам хүчин төгөлдөр болох

Энэхүү журам нь 2023 оны 4 сарын 11-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.